



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ӨМА-2023/118/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас:99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Болормаа
Утас:80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК
Утас:99099119 Цахим хаяг:gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн үндэслэлийн ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 48083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудал: www.audit.mn
Цахим шуудан: info@audit.gov.mn

2022.12.14 № 40

талаа _____ -ыг № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодрууллагууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Даланзадгад сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журм, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд захистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр 6 дугаар ангийн хүүхдүүдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтад "Хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал" батлагдаж боловсролын байгууллагын жилжйн эцсийн дансны үндэгдлийг дараагийн төсвийн жилд санхүүжүүлдэг болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамваатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

016010053

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нэгтгэн бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нэгтгэн бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэгтэнгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

	(сая төгрөгөөр)	
Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	222.6	427.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,662.4	3,047.9
Нийт хөрөнгийн дүн	2,885.1	3,475.1
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,885.1	3,475.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,885.1	3,475.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	1,677.3	2,724.0
Үйл ажиллагааны зардлын дүн	1,621.1	2,211.3
Үйл ажиллагааны үр дүн	56.2	512.8
Үйл ажиллагааны бус үр дүн	(0.4)	(3.8)
Үйл ажиллагааны нийт үр дүн	55.8	508.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Засгийн газрын оруулсан капитал	798.6	879.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,044.8	1,044.8
Хуримтлагдсан үр дүн	1,041.6	1,551.1

Эцсийн үлдэгдэл	2,885.1	3,475.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,505.7	2,371.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,454.8	2,170.5
Үйл ажиллагааны ЦМГ	50.9	200.4
Хөрөнгө оруулалтын ЦМГ	2.2	-
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	48.7	200.4
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	200.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,281.6	2,085.1
Урсгал зардал	2,281.6	2,085.1
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,281.6	2,258.7
Улсын төсвөөс санхүүжих	2,075.8	2,075.8
Орон нутгийн төсвөөс санхүүжих	205.7	178.9
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		178.9

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 31.5 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа.

Аудитаар Саммит компьютер ХХК-иад 24.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн үнэ шилжүүлээд захиалсан тоног төхөөрөмж нь ирээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгасан, ФючерсСкүүл Монголий ХХК-с худалдан авсан, Шалгалтын хариу засах 7.0 сая төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг шууд зардалд бүртгэсэн, балансаас баланс хооронд фургон маркийн машин шилжүүлэхдээ 0.1 сая төгрөгийн элэгдлийн зардлын дансны бичилт буруу тайлагнагдсан алдааг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 11.4 сая төгрөгийн зөрчил² илрүүлж тус зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 оны 8 сард Бат арвай трейд ХХК-иас 11.4 сая төгрөгийн компьютерыг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад газраас худалдан авдаг байдлыг зогсоож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

												/мянган төгрөгөөр/	
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
							Залруулсан		Залруулаагүй				
	Тоо	Дүн		Дүн	Тоо	Дүн		Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Авлагыг данс бүртгэлд тусгаагүй	1	24,405.00			1	24,405.00	1	24,405.00					
Програм хангамжийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлгүй шууд зардалд бүртгэсэн	1	7,000.00			1	7,000.00	1	7,000.00					
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардалыг буруу бүртгэсэн	1	142.30			1	142.30	1	142.30					
Дүн	3	31,547.30			3	31,547.30	3	31,547.30					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хууль	1	11,400.0					1	11,400.0
Дүн	1	11,400.0					1	11,400.0
Нийт дүн	1	11,400.0					1	11,400.0